



“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ” НӨТБ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Музейн 100 жилийн ой, ОУ-ын музейн өдрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөө, зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 49.2.3 дахь заалт, Музейн тухай хуулийн 7.6 дахь хэсэг, Соёлын сайдын 2023 оны А/478 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Соёлын дэд сайдын баталсан “Монгол улсад орчин цагийн музейн салбар байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Олон улсын музейн өдрөөр “Музей боловсрол, судалгааны төлөө” сэдвийн дор зохион байгуулах удирдамжийн дагуу тус музейгээс зохион байгуулах ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажлын хүрээнд зохион байгуулах арга хэмжээний 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг батлагдсан төсвийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.


3.Төлөвлөгөөт арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг менежер (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



П.ДАВААСҮРЭН

Музейн захирлын 2024 оны 05. дугаар сарын 13-ны өдрийн А/19 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МУЗЕЙ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛ, ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДӨРТ ЗОРИУЛСАН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 05 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Эхлэх, дуусах огноо	Хариуцах эзэн	Төсөв (төгрөгөөр)
1	2	3	4	5	6	
НЭГ. "МУЗЕЙ БОЛОВСРОЛ, СУДАЛГААНЫ ТӨЛӨӨ" ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДӨРТ ЗОРИУЛСАН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ						
1.1.	Олон улсын музейн өдөрт зориулан зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан музейн захирлаар батлуулах	Төлөвлөгөө батлуулсан байна.	1	05/13	Арга зүйч	
1.2.	Олон улсын музейн зөвлөлөөс гаргасан "МУЗЕЙ БОЛОВСРОЛ СУДАЛГААНЫ ТӨЛӨӨ" уриа логонд тулгуурлан музейгээс зохион байгуулах ажлын хөтөлбөр бүхий зурагт хуудас, музейн танилцуулга (тараах материал) баннер бэлтгэх	Зурагт хуудас, баннер, музейн танилцуулга бэлтгэн хэвлэсэн байна.	1	05/15	Арга зүйч Дизайнер	390,000
1.3.	Музейн цахим хуудас, ОУМЗөвлөлийн цахим хуудаст Улаанбаатар хотын музейгээс зохион байгуулах хөтөлбөрийг байршуулах	Цахим хуудаст мэдээлэл байршсан байна.	2	05/15-18	Арга зүйч Дизайнер	
1.4.	Улаанбаатар хотын захиргаа байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Улаанбаатар 1924-1954 он" сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэнг музейн үзэгчдэд тайлбарлан таниулах	Үзэгчдэд тайлбарт үйлчилгээ үзүүлсэн байна.	1	05/15-18	Тайлбарлагч	

1.5.	“Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” – боловсрол танин мэдэхүйн ажил зохион байгуулах - БИС-ын лицей сургуулийн 4-р ангийн 39 сурагчдад (Бичиг хэргийн материал - будах, зурах материал, принтрийн хор, бичгийн цаас худалдан авах)	Боловсролын ажил зохион байгуулсан байна.	1	05/16	Боловсролын ажилтан ЭША Тайлбарлагч	450,000
1.6.	Нээлтэд зориулан музейг агаарын бөмбөлөгөөр чимэглэх	Агаарын бөмбөлөгөөр чимэглэсэн байна.	1	05/17	Нярав Жижүүр Тайлбарлагч	100,000
1.7.	Чойжин ламын сүм музейд “Музей боловсрол судалгааны төлөө” сэдэвт олон улсын музейн өдрийн нэгдсэн арга хэмжээнд оролцох	Нэгдсэн нээлтийн арга хэмжээнд оролцсон байна.	1	05/18	Байгууллагын төлөөлөл	
1.8.	ОУМӨ-т зориулан зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг бичиж “ОУМЗ-ийн Монгол дахь үндэсний хороо”-нд илгээх	ОУМЗ-ийн Монгол дахь үндэсний хорооны нэгдсэн тайланд орсон байна.	1	05/18-05/25	Арга зүйч	
1.9.	ОУМӨ-т зориулан зохион байгуулсан үйл ажиллагааг байгууллагын болон бусад цахим хуудаст байршуулан сурталчлах	Цахим хуудаст мэдээлэл байршсан байна.	1	05/18-05/25	Дизайнер	
	Дүн					940,000

ХОЁР. МОНГОЛ УЛСАД ОРЧИН ЦАГИЙН МУЗЕЙ ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН МУЗЕЙН ТАНИЛЦУУЛГА, ШТОРК БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1	Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааг харуулсан богино хэмжээний видео бичлэг (шторк) хийх төлөвлөгөө боловсруулан музейн захирлаар батлуулах	Төлөвлөгөө батлуулсан байна.	1	05/01	Дизайнер	-
2.2	Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааг харуулсан богино хэмжээний видео бичлэг (шторк) хийх ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	Гэрээ байгуулсан байна.	1	05/01	Дизайнер	-
2.3	Видео бичлэгт хэрэглэгдэх мэргэжлийн тоног төхөөрөмж түрээслэх	мэргэжлийн тоног төхөөрөмж түрээслэсэн байна.	1	05/03	Дизайнер	450,000

2.4	Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааг харуулсан видео бичлэгийн зохиол боловсруулах	Зохиол боловсруулсан байна.	1	05/03	Захирал Дизайнер	-
2.5	Танилцуулга бичлэгт оролцох музейн онцлогыг харуулсан үзмэр сонгон жагсаалт гаргах, үзмэрийн болон үзүүлэгийн танхимын бичлэг хийлгэх	Үзмэрийн жагсаалт гарган, бичлэг хийлгэсэн байна.	1	05/06	Зураглаач Сан хөмрөгч БМСанч	120,000
2.6	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан мэргэжлийн зураглаачаар үзмэрийн бичлэг хийлгэх	Үзмэрийн бичлэг хийлгэсэн байна	1	05/08	Зураглаач Дизайнер	120,000
2.7	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан мэргэжлийн зураглаачаар музейн захирлын мэндчилгээ, музейн барилгын план зураг бүхий бичлэг хийлгэх	Бичлэг хийсэн байна.	1	05/08	Зураглаач Дизайнер	120,000
2.8	Хийгдсэн бичлэгийн монтаж хийн, бэлэн болгох	Бичлэг бэлэн болсон байна.	1	05/15	Дизайнер	-
2.9	Бэлэн болсон шторкыг Музейн 100 жилийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж буй Чойжин ламын сүм музейн templemuseum14@gmail.com хаягаар илгээх	Бичлэг илгээсэн байна.	1	05/18	Дизайнер	-
	Дүн (Задаргааг гэрээнээс харах)					860,000
	Нийт дүн					1,800,000